



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/066/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Аудитор: Т.Баасанцэнд
Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/658

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сангийн яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг бэхжүүлэх төсөл”-өөс 8,982,046.3 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 1,956,094.7 мянган төгрөгийн программ хангамж, нийт 10,938,141.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, ТНБД-ын 2024 оны А/282 дугаар тушаалын дагуу Сангийн яамны санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын зэрэглэл тогтоох үйлчилгээний төлбөр арга хэмжээнд тайлант онд 780,091.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 574,649.1 мянган төгрөгийг зэрэглэл тогтоох төлбөрт төлсөн байна. Тус арга хэмжээний үр дүнд Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч "S&P" агентлагаас Монгол улсын 2024 оны зээлжих зэрэглэлийг "B+ зэрэг" болж сайжирсныг мэдэгдсэн байна. Зээлжих зэрэглэл тогтоогч "Fitch Ratings", "S&P", "Moody's" гэсэн олон улсын агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B+зэрэг", "B+тогтвортой" болгон нэмэгдүүлснээр Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагчдын итгэх итгэл сайжирч, шууд хөрөнгө оруулалтын суурь бэхжиж, улмаар зээлжих зэрэглэл дахин өсөх боломж бүрдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сангийн яам нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	68,918,650,167.76	143,123,691,901.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	67,865,405,563.45	141,987,639,808.11
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	67,865,405,563.45	141,987,639,808.11
31210	Төгрөг	67,865,405,563.45	141,987,639,808.11
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк дахь харилцах (НД)	67,513,626,813.15	141,987,639,808.11
31217	Төрийн сангийн харилцах - орон нутаг	351,778,750.30	-
33	АВЛАГА	30,847,439.46	20,935,171.16
33300	Татаас, санхүүжилтийн авлага	24,775,104.84	14,862,836.44
33500	Бусад авлага	6,072,334.62	6,072,334.72
33510	Байгууллагаас авах авлага	6,072,334.62	6,072,334.72
34	УРЬДЧИЛГАА	57,102,800.00	614,271,609.77
34600	Урьдчилж гарсан зардал	57,102,800.00	614,271,609.77
35	БАРАА МАТЕРИАЛ	965,294,364.85	500,845,312.29
35100	Түүхий эд материал	13,030,000.00	11,660,000.00
35110	Тусгай зориулалттай материал	13,030,000.00	11,660,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	214,787,734.68	143,675,068.00
35400	Хангамжийн материал	713,426,630.17	317,510,244.29
35410	Бичиг хэргийн материал	7,400,200.00	13,942,700.00
35420	Аж ахуйн материал	668,188,576.40	257,731,144.29
35430	Сэлбэг хэрэгсэл	37,584,200.00	45,836,400.00
35440	Түлш, шатах тослох материал	253,653.77	-
35600	Мал амьтад	24,050,000.00	28,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	16,298,303,408.57	26,400,429,434.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,298,303,408.57	26,400,429,434.87
39200	Биет хөрөнгө	16,045,152,501.98	24,354,205,794.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,914,357,792.71	13,914,357,792.71
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(2,166,274,330.74)	(2,488,171,858.82)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	555,200,000.00	793,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(224,865,877.59)	(430,405,877.55)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,712,266,901.96	18,673,147,407.13
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(4,988,635,396.90)	(6,480,267,832.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	924,409,711.67	1,104,668,700.81
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(687,251,203.12)	(738,767,441.14)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,738,100.00	1,738,100.00
39217	Номын фонд	4,206,804.00	4,206,804.00
39300	Биет бус хөрөнгө	253,150,906.59	2,046,223,640.57
39301	Программ хангамж	2,603,990,383.00	4,567,212,233.92
39302	Хуримтлагдсан элэгдэл-Программ хангамж	(2,374,379,736.41)	(2,544,528,853.35)
39303	Бусад биет бус хөрөнгө	23,540,260.00	23,540,260.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	85,216,953,576.33	169,524,121,336.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	1,186,170,856.38	5,497,396,879.54
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,186,170,856.38	5,497,396,879.54
41300	Өглөг	1,186,170,856.38	5,497,396,879.54
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,186,170,856.38	5,497,396,879.54
413213	Бусад зардлын өглөг	1,186,170,856.38	5,497,396,879.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	84,030,782,719.95	164,026,724,456.66
51	Засгийн газрын хувь оролцоо	84,030,782,719.95	164,026,724,456.66
51101	-Төрийн	5,955,750,087.17	5,955,750,087.17
51200	Хуримтлагдсан үр дүн	74,690,271,536.62	154,686,213,273.33
51210	Өмнөх үеийн үр дүн	23,478,645,486.67	74,690,271,536.62

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	51,211,626,049.95	79,995,941,736.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,384,761,096.16	3,384,761,096.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	85,216,953,576.33	169,524,121,336.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	76,673,958,267.04	176,801,924,263.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,239,027,770.04	149,236,896,136.64
1200	Нийтлэг татварын бус орлого	59,239,027,770.04	149,236,896,136.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,267,497.47	8,211,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	4,797,497.47	5,521,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,470,000.00	2,690,000.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	58,654,303,626.00	136,557,915,336.80
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	572,847,605.57	12,664,469,029.85
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	5,609,041.00	6,300,569.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,434,930,497.00	27,565,028,126.68
1310	Улсын төсвөөс	16,780,105,992.00	18,857,984,261.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,780,105,992.00	18,857,984,261.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	654,824,505.00	8,707,043,865.68
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	654,824,505.00	585,446,852.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	6,875,891,221.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,245,705,792.60
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	25,455,432,217.09	95,908,732,379.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,995,481,104.88	36,741,551,523.46
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,173,323,616.09	25,396,004,346.62
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,572,685,239.83	6,715,258,934.70
210101	Үндсэн цалин	2,552,027,634.75	3,269,494,852.60
210102	Нэмэгдэл	1,853,445,594.38	2,028,102,831.82
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	557,691,701.60	813,288,811.50
210104	Урамшуулал	609,520,309.10	604,372,438.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	754,961,229.42	870,753,634.23
210201	Тэтгэврийн даатгал	514,026,079.91	572,756,615.70
210202	Тэтгэмжийн даатгал	66,963,897.99	72,951,598.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,169,193.87	42,625,181.24
210204	Ажилгүйдлийн даатгал	13,395,532.51	35,207,550.48
210205	Эрүүл мэндийн даатгал	113,406,525.14	147,212,688.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	274,897,214.48	279,681,328.67
210301	Гэрэл, цахилгаан	237,940,515.48	238,382,201.90
210302	Түлш, халаалт	26,234,728.00	31,015,054.81
210303	Цэвэр, бохир ус	10,721,971.00	10,284,071.96
2104	Хангамж, бараа материалын зардал	238,378,926.24	729,062,199.70
210401	Бичиг хэрэг	51,850,750.00	65,605,100.00
210402	Тээвэр, шатахуун	66,058,303.00	80,347,716.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,158,081.24	54,221,138.70

**Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,971,098.00	50,892,760.00
210408	Бараа материал акталсны зардал	40,340,694.00	477,011,485.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	984,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,850,450.00	355,197,831.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	173,000.00	-
210604	Урсгал засвар	38,677,450.00	355,197,831.00
2107	Томилолт, зочны зардал	113,681,447.00	155,834,695.00
210702	Дотоод албан томилолт	113,681,447.00	155,834,695.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,143,113,403.70	3,684,824,215.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,924,560,121.60	2,725,561,496.34
210803	Даатгалын үйлчилгээ	8,452,860.00	12,857,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	456,224.00	381,426.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	208,822,598.10	945,361,232.80
210807	Газрын төлбөр	621,600.00	618,870.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,036,755,705.42	12,605,391,508.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,623,167,721.60	10,537,499,431.22
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	2,413,587,983.82	2,067,892,076.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,822,157,488.79	11,345,547,176.84
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	887,027,193.69	579,072,730.90
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	887,027,193.69	579,072,730.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,225,853,926.00	1,118,038,357.83
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	553,924,000.00	751,900,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	263,100,000.00	290,550,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	156,268,926.00	58,238,357.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	252,561,000.00	17,350,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,709,276,369.10	2,068,709,828.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,709,276,369.10	2,068,709,828.37
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,579,726,259.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,579,726,259.74
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,459,951,112.21	59,167,180,855.56
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,390,442,808.00	59,167,180,855.56
220001	Барилга байгууламж	1,390,442,808.00	59,167,180,855.56
222	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	1,766,825,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	1,766,825,000.00	-
223	БУСАД ХӨРӨНГӨ	302,683,304.21	-
223001	Бусад хөрөнгө	302,683,304.21	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	51,218,526,049.95	80,893,191,884.30
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	6,900,000.00	897,250,147.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	6,900,000.00	897,250,147.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	897,250,147.60
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа материал	6,900,000.00	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	51,211,626,049.95	79,995,941,736.70

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	78,015,455,772.84	168,988,096,518.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,580,525,275.84	141,398,293,286.56
1200	Нийтлэг татварын бус орлого	60,580,525,275.84	141,398,293,286.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,042,000.00	5,521,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	6,042,000.00	5,521,200.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	60,574,483,275.84	141,392,772,086.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,434,930,497.00	27,589,803,231.52
1310	Улсын төсвөөс	16,780,105,992.00	18,857,984,261.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,780,105,992.00	18,857,984,261.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	654,824,505.00	8,731,818,970.52
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	654,824,505.00	585,446,852.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	6,875,891,221.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,270,480,897.44
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	19,245,073,338.84	34,772,251,470.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,245,073,338.84	34,772,251,470.26
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,364,965,405.90	23,411,841,456.98
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,571,489,320.15	6,715,258,934.70
210101	Үндсэн цалин	2,550,831,715.07	3,269,494,852.60
210102	Нэмэгдэл	1,853,445,594.38	2,028,102,831.82
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	557,691,701.60	813,288,811.50
210104	Урамшуулал	609,520,309.10	604,372,438.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	754,961,229.42	870,753,634.23
210201	Тэтгэврийн даатгал	514,026,079.91	572,756,615.70
210202	Тэтгэмжийн даатгал	66,963,897.99	72,951,598.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,169,193.87	42,625,181.24
210204	Ажилгүйдлийн даатгал	13,395,532.51	35,207,550.48
210205	Эрүүл мэндийн даатгал	113,406,525.14	147,212,688.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	274,897,214.48	279,681,328.67
210301	Гэрэл, цахилгаан	237,940,515.48	238,382,201.90
210302	Түлш, халаалт	26,234,728.00	31,015,054.81
210303	Цэвэр, бохир ус	10,721,971.00	10,284,071.96
2104	Хангамж, бараа материалын зардал	161,882,469.24	192,641,648.70
210401	Бичиг хэрэг	49,803,850.00	52,848,700.00
210402	Тээвэр, шатахуун	33,046,000.00	20,198,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,158,081.24	54,221,138.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,874,538.00	65,373,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,107,210.00	384,918,731.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,651,760.00	15,585,500.00
210604	Урсгал засвар	53,455,450.00	369,333,231.00
2107	Томилолт, зочны зардал	151,013,152.00	210,514,195.00
210702	Дотоод албан томилолт	151,013,152.00	210,514,195.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,385,897,503.70	4,245,044,920.14

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,923,060,121.60	2,734,049,829.34
210803	Даатгалын үйлчилгээ	8,452,860.00	12,857,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	456,224.00	381,426.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	453,106,698.10	1,497,093,604.80
210807	Газрын төлбөр	621,600.00	618,870.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,004,717,306.91	10,513,028,064.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,004,717,306.91	10,513,028,064.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,880,107,932.94	11,360,410,013.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	883,462,533.00	579,072,730.90
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	883,462,533.00	579,072,730.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,262,593,926.00	1,118,038,357.83
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	590,664,000.00	751,900,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	263,100,000.00	290,550,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	156,268,926.00	58,238,357.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	252,561,000.00	17,350,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,734,051,473.94	2,083,572,664.81
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	464,883,056.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,734,051,473.94	1,618,689,608.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,579,726,259.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,579,726,259.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	58,770,382,434.00	134,215,845,047.82
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,384,572,332.72	60,093,610,803.16
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,384,572,332.72	60,093,610,803.16
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4,051,457,261.51	59,690,811,582.16
220001	Барилга байгууламж	4,051,457,261.51	59,690,811,582.16
221	ИХ ЗАСВАР	47,817,166.00	-
221001	Их засвар	47,817,166.00	-
222	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	2,866,655,793.00	-
222001	Тоног төхөөрөмж	2,866,655,793.00	-
223	БУСАД ХӨРӨНГӨ	302,683,304.21	-
223001	Бусад хөрөнгө	302,683,304.21	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	115,958,808.00	402,799,221.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	115,958,808.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	115,958,808.00	402,799,221.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(7,384,572,332.72)	(60,093,610,803.16)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	51,385,810,101.28	74,122,234,244.66
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,479,595,462.17	67,865,405,563.45
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,865,405,563.45	141,987,639,808.11

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,955,750,087.17	3,384,761,096.16	23,478,645,486.68	32,819,156,670.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,955,750,087.17	3,384,761,096.16	23,478,645,486.68	32,819,156,670.01
9	Тайлант үеийн үр дүн	-	-	51,211,626,049.95	51,211,626,049.95
11	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,955,750,087.17	3,384,761,096.16	74,690,271,536.62	84,030,782,719.95
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,955,750,087.17	3,384,761,096.16	74,690,271,536.62	84,030,782,719.95
19	Тайлант үеийн үр дүн	-	-	79,995,941,736.70	79,995,941,736.70
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,955,750,087.17	3,384,761,096.16	154,686,213,273.33	164,026,724,456.66

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,870,001,000.00	17,447,443,532.63	4,422,557,467.37	79.8
УРСГАЛ ЗАРДАЛ	21,870,001,000.00	17,447,443,532.63	4,422,557,467.37	79.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,522,969,900.00	15,750,332,443.90	3,772,637,456.10	80.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,115,655,400.00	6,715,258,934.70	400,396,465.30	94.4
Үндсэн цалин	3,825,887,500.00	3,269,494,852.60	556,392,647.40	85.5
Нэмэгдэл	2,110,565,500.00	2,028,102,831.82	82,462,668.18	96.1
Унаа хоолны хөнгөлөлт	673,370,200.00	813,288,811.50	(139,918,611.50)	120.8
Урамшуулал	505,832,200.00	604,372,438.78	(98,540,238.78)	119.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	889,456,700.00	870,753,634.23	18,703,065.77	97.9
Тэтгэврийн даатгал	604,830,600.00	572,756,615.70	32,073,984.30	94.7
Тэтгэмжийн даатгал	71,156,500.00	72,951,598.46	(1,795,098.46)	102.5
ҮОМШӨ-ний даатгал	35,578,200.00	42,625,181.24	(7,046,981.24)	119.8
Ажилгүйдлийн даатгал	35,578,300.00	35,207,550.48	370,749.52	99.0
Эрүүл мэндийн даатгал	142,313,100.00	147,212,688.35	(4,899,588.35)	103.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	305,685,100.00	279,681,328.67	26,003,771.33	91.5
Гэрэл, цахилгаан	250,000,000.00	238,382,201.90	11,617,798.10	95.4
Түлш, халаалт	42,859,600.00	31,015,054.81	11,844,545.19	72.4
Цэвэр, бохир ус	12,825,500.00	10,284,071.96	2,541,428.04	80.2
Хангамж, бараа материалын зардал	206,198,000.00	193,141,638.70	13,056,361.30	93.7
Бичиг хэрэг	58,000,000.00	52,848,700.00	5,151,300.00	91.1
Тээвэр, шатахуун	20,198,000.00	20,198,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,000,000.00	54,221,138.70	2,778,861.30	95.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,000,000.00	65,873,800.00	5,126,200.00	92.8
Эд хогшил, урсгал засварын зардал	226,200,000.00	179,722,100.00	46,477,900.00	79.5
Багаж, техник хэрэгсэл	136,200,000.00	88,212,000.00	47,988,000.00	64.8
Тавилга	10,000,000.00	7,529,750.00	2,470,250.00	75.3
Урсгал засвар	80,000,000.00	83,980,350.00	(3,980,350.00)	105.0
Томилолт, зочны зардал	210,774,200.00	210,514,195.00	260,005.00	99.9
Дотоод албан томилолт	210,774,200.00	210,514,195.00	260,005.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	5,264,164,200.00	4,245,044,920.14	1,019,119,279.86	80.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,390,975,600.00	2,734,049,829.34	656,925,770.66	80.6
Даатгалын үйлчилгээ	16,740,800.00	12,857,190.00	3,883,610.00	76.8
Тээврийн хэрэгслийн татвар	1,544,300.00	381,426.00	1,162,874.00	24.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	490,500.00	44,000.00	446,500.00	9.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,853,775,400.00	1,497,093,604.80	356,681,795.20	80.8
Газрын төлбөр	637,600.00	618,870.00	18,730.00	97.1
Бараа үйлчилгээний бусад зардал	5,304,836,300.00	3,056,215,692.46	2,248,620,607.54	57.6
Бараа үйлчилгээний бусад зардал	5,304,836,300.00	3,056,215,692.46	2,248,620,607.54	57.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,347,031,100.00	1,697,111,088.73	649,920,011.27	72.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	981,000,000.00	579,072,730.90	401,927,269.10	59.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	981,000,000.00	579,072,730.90	401,927,269.10	59.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	785,060,000.00	751,900,000.00	33,160,000.00	95.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	294,832,000.00	290,550,000.00	4,282,000.00	98.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	254,747,100.00	58,238,357.83	196,508,742.17	22.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,392,000.00	17,350,000.00	14,042,000.00	55.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,870,001,000.00	17,447,443,532.63	4,422,557,467.37	79.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,870,001,000.00	17,441,922,332.63	4,428,078,667.37	79.8

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

Улсын төсвөөс санхүүжих	21,870,001,000.00	17,441,922,332.63	4,428,078,667.37	79.8
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	5,521,200.00	(5,521,200.00)	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	167	152	15	91.0
Удирдах ажилтан	27	25	2	92.6
Гүйцэтгэх ажилтан	140	127	13	90.7

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)		8,731,818,970.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,731,818,970.52
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,064,308,234.08
2104	Хангамж, бараа материалын зардал		898,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		898,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		591,762,862.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		131,110,790.00
210602	Тавилга		77,489,700.00
210604	Урсгал засвар		383,162,372.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		7,471,647,372.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		7,471,647,372.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		667,510,736.44
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		667,510,736.44
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		667,510,736.44
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)		8,731,818,970.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		8,731,818,970.52
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,731,818,970.52
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		585,446,852.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан		6,875,891,221.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,270,480,897.44
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 834,572.0 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Жилийн хугацаанд ашиглагдах, тайлант оны дундуур худалдан авсан "Халдлагаас хамгаалах систем"-ийн эрхийн дараа онд ногдох 129,661.4 мянган төгрөгийн зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэж, Санхүүгийн байдлын тайланд толилуулаагүй.	1	129,661.4			1	129,661.4	1	129,661.4				
2	Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэг шилжүүлгийн дүнг 52,262.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	52,262.7			1	52,262.7	1	52,262.7				
3	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан "Уул уурхайн дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн арилжааны банканд байршиж байсан хүүгийн орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй, нэмэлт санхүүжилтээр авч, тайлант оны эцэст үлдэгдэл 652,647.9 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.	1	652,647.9			1	652,647.9	1	652,647.9				
	Дүн	3	834,572.0	-	-	3	834,572.0	3	834,572.0	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Сангийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар нийт 236,684.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 236,684.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Урсгал төсвөөс Дэлхийн банк Олон Улсын валютын сангийн 2024 оны намрын уулзалтад оролцох УИХ-ын 8 гишүүний 6 хоногийн албан томилолтын зардлыг тооцож олгохдоо өдрийн зочид буудлын зардлыг хүн бүрд 40,800.0 мянган төгрөгөөр, онгоцны тийзийн төлбөрийг 137,609.6 мянган төгрөгөөр, нийт 178,409.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон. Мөн хэвлэл мэдээллийн 3 ажилтны гадаад томилолтын 39,291.6 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан зэрэг өөрийн төсөвт хамааралгүй зардлуудыг санхүүжүүлсэн.	1	217,701.2	-	-	-	-	1	217,701.2	-	-	-	-
2	Тайлант онд 1 аж ахуйн нэгжтэй 9 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 18,983.4 мянган төгрөгийг олгосон боловч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гүйцэтгэлийг үнэлээгүй байна.	1	18,983.4	-	-	-	-	1	18,983.4	-	-	-	-
3	Тайлант хугацаанд төсөв захирагчийн кассын арилжааны банкны харилцах данснаас нийт 1,020,354.0 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээ гарсан.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	3	236,684.6	-	-	-	-	3	236,684.6	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
				Үүнээс			Зөвлөмж		
		ТОО	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	ТОО	Дүн	ТОО	Дүн
Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим хуудсанд 7 төрлийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	-	-	1	-